

Хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийн үр дүнд өгөх суралцагчдийн үнэлгээ

М.Өсөхбаяр¹, Н.Эрдэнэхүү², Я.Энхтөр³, Б.Оюунгоо⁴

¹ Өрхийн анагаах ухааны тэнхим, Анагаах ухааны сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

² Хавдар судлалын үндэсний төв

³ Анагаах ухааны сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

⁴ Сувшлахуйн сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль

Цахим шуудан: usukhbayar@mnums.edu.mn, Умас: 99080154

Түлхүүр үг:

Хөтөлбөр, үр дүнд
суурилсан боловсрол,
үнэлгээ, сэтгэл
ханамж, хүчин зүйлийн
шинжилгээ

Товч утга:

Үндэслэл: Орчин үеийн анагаахын боловсролд үр дүнд суурилсан боловсрол (Outcome-Based Education, OBE) болон асуудалд суурилсан сургалт (Problem-Based Learning, PBL) хандлагыг хослуулан хэрэглэх нь сургалтын чанарыг сайжруулах гол чиг хандлага болоод байна. АШУУИС нь 2013 оноос эхлэн OBE хөтөлбөрийг нэвтрүүлсэн нь уг шинэчлэлийн үр нөлөө, сургалтын чанарт үнэлгээ хийх хэрэгцээг бий болгосон. Суралцагчдын сэтгэл ханамж нь боловсролын чанарыг хэмжих чухал шалгуур төдийгүй төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагад нөлөөлдөг тул энэ чиглэлээр судалгаа хийх шаардлагатай. **Зорилго:** Хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрт суралцагчдын сэтгэл ханамжийн түвшин болон түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, сургалтын чанарыг сайжруулах үндэслэлийг гаргах.

Арга, аргачлал: 2023–2024 онд АШУУИС-ийн Хүний их эмчийн хөтөлбөрийн 3–6-р дамжааны 1167 оюутны дунд асуумжийн судалгаа явуулсан. Оролцогчдын дундаж нас 22.2 ± 1.5 жил байсан бөгөөд 79.9% нь эмэгтэй суралцагчид байв. Суралцагчдын сургалтын чанарт өгч буй сэтгэл ханамжийг 23 асуулт бүхий асуумжаар (16 асуумж нь 5 онооны Ликертийн хэмжигдэхүүн) үнэлэн цуглуулсан. Өгөгдлийг SPSS 26 програм ашиглан боловсруулж, дескриптив статистик, хамааралгүй хоёр бүлгийн t-шинжилгээ, нэг хүчин зүйлт дисперсийн шинжилгээ (ANOVA), Пирсоны корреляци, хүчин зүйлийн шинжилгээ болон олон хувьсагчийн регрессийн шинжилгээг хийв. Статистикийн хувьд $p < 0.05$ утгыг ач холбогдолтойд тооцсон. **Үр дүн:** Сэтгэл ханамжийн асуумжийн найдвартай байдал маш өндөр (Cronbach's $\alpha = 0.927$) байв. Нийт суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.51 ± 0.84 байсан нь дунджаас дээш түвшнийг илтгэлээ. 4-р дамжааны суралцагчид багшийн заах аргын чанарт хамгийн өндөр үнэлгээ өгсөн (дундаж 3.97 ± 0.67) бол 3-р дамжааны суралцагчид сургалтын материал, хэрэглэгдэхүүний хүрэлцээнийг хамгийн бага үнэлсэн (дундаж 2.98 ± 1.01); эдгээр ялгаа нь статистикийн хувьд өндөр ач холбогдолтой байв ($p < 0.001$). Түүнчлэн, эмнэлзүйн сургалтын үнэлгээ төгсөх дамжаанд буурч, 6-р дамжааны үнэлгээ 3-р дамжааныхтай харьцуулахад доогуур байсан (дундаж 3-р дамжаанд 3.70, 6-р дамжаанд 3.16; $p < 0.001$). Нийт сэтгэл ханамжийн үнэлгээ хүйсийн ялгаагаар зөрүүгүй байсан ($p > 0.05$). Хүчин зүйлийн шинжилгээгээр сургалтын чанарын үнэлгээнд нөлөөлөх хоёр үндсэн хүчин зүйл илэрсэн (КМО = 0.950; Bartlett-ийн тест $p < 0.001$) ба эдгээр нь нийт вариацийн 55.83%-ийг тайлбарлаж байв. Нэгдүгээр хүчин зүйл нь сургалтын зохион байгуулалт, хичээлийн агуулга, багшийн арга зүй зэрэг сургалтын үйл явцын чанарт хамаарах үзүүлэлтүүдийг нэгтгэсэн бол хоёрдугаар хүчин зүйл нь сургалтын материаллаг орчин, нөөц боломж, ачаалал зэрэг орчны нөхцөлийн үзүүлэлтүүд байлаа. Мөн корреляци, регрессийн шинжилгээний дүнгээр сургалтын зохион байгуулалт сайтай байдал, багшийн идэвхтэй оролцоо зэрэг нь суралцагчдын сэтгэл ханамжид эерэг хамааралтай болох нь тогтоогдов ($p < 0.01$).

Дүгнэлт: Сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээлүүдийн уялдаа холбоо болон багшийн заах арга зүйг тасралтгүй сайжруулах шаардлагатай байна. Мөн төгсөх дамжааны (6-р дамжаа) суралцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн тулд сургалтын орчны нөөц, материаллаг баазыг сайжруулж, сургалтын арга барилыг шинэчлэх нь чухал байна. Судалгааны дүн нь цаашдын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, чанарыг сайжруулах бодлого төлөвлөлтөд нотолгоонд суурилсан үндэслэл болох боломжтойг харуулж байна.

Үндэслэл: Орчин үеийн анагаахын боловсролд үр дүнд суурилсан боловсрол (Outcome-Based Education, OBE) болон асуудалд суурилсан сургалт (Problem-Based Learning, PBL) нь түгээмэл баримтлал болж, сургалтын арга зүйд томоохон өөрчлөлт авчирсан байна. Үр дүнд суурилсан боловсрол нь суралцагчдын эзэмших ёстой мэдлэг, чадвар, төлөвшлийг урьдчилан тодорхойлж, сургалтын бүхий л үйл явцыг эдгээр зорилтот үр дүнд чиглэлээрээ онцлог байдаг.¹ Харин PBL нь асуудал шийдвэрлэх замаар сургалтыг явуулж, оюутны идэвхтэй оролцоо, бие даан суралцах үйл явцыг дэмждэг сургах арга юм. Практикт эдгээр хандлагуудыг ялган хэрэгжүүлэхээс илүү харилцан хослуулан ашиглах нь үр дүнтэй болохыг олон улсын судалгаануудад тодорхойлогдсон байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд ихэнх анагаахын сургуулиуд сургалтын бүтэц, хөтөлбөрөө үр дүн (чадамж)-д төвлөрүүлэн шинэчилж, уламжлалт лекц, багшийн төвтэй аргыг багасган, багийн болон тохиолдол дээр суурилсан арга барилыг нэмэгдүүлжээ.² Өөрөөр хэлбэл, өмнө нь зөвхөн PBL-д хамаардаг байсан гэж үздэг байсан цөөн лекц, жижиг группийн ажил, хөндлөн болон босоо интеграц зэрэг арга зүйг орчин үеийн ихэнх хөтөлбөрүүд хэвийн хэрэглэж, сургалтын арга барил үйл явцаас илүү гарцыг чухалчилсан шинэ шатанд шилжижээ.³ Суралцагчийн сэтгэл ханамж нь боловсролын чанарыг үнэлэх чухал шалгуур үзүүлэлт гэж хүлээн зөвшөөрөгдсөн байдаг.⁴ Дээд боловсролын байгууллагуудын гүйцэтгэлийг үнэлэхэд оюутны сэтгэл ханамжийн түвшин чухал үзүүлэлт болдог бөгөөд энэ нь төгсөгчдийн тогтвор суурьшилт, сургуулийн нэр хүнд, зэрэглэлд хүртэл нөлөөлдөг болохыг судалгаанууд дурьджээ.⁵

АШУҮИС нь асуудалд суурилсан сургалтаас 2013 онд үр дүнд суурилсан боловсрол руу шилжсэн тул энэхүү сургалтын арга хэлбэрээр суралцаж буй суралцагчдын сургалтын чанарт өгөх сэтгэл ханамжийг судлах шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Ийнхүү сургалтын шинэчлэл хийгдсэнтэй холбоотойгоор түүний үр нөлөө, чанарт үнэлгээ, шинжилгээ хийх хэрэгцээ нэмэгдсэн юм.⁶ АШУҮИС-ийн хувьд сүүлийн арван жилд сургалтын хөтөлбөрийнхөө чанарыг олон улсын хэмжээнд харьцуулан үнэлүүлэх алхмуудыг хийж эхэлсэн ба үүний нэг жишээ нь хүний их эмч бэлтгэх хөтөлбөрийг Европын ASIIN байгууллагаар 2024 онд дахин амжилттай магадлан итгэмжлүүлсэн явдал юм.⁷

Энэхүү судалгааг хийснээр бид хүний их эмч бэлтгэх хөтөлбөртөө хүний их эмчээр суралцаж буй суралцагчдаар үнэлүүлж сургалтын чанарын бодлого боловсруулах, багшийн оролцоог төлөвлөх, блок сургалтын бүтцийг сайжруулахад

шууд хэрэглэгдэхүйц дүгнэлт гаргана гэсэн үүднээс энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.

Зорилго: АШУҮИС –ийн “Хүний их эмч” бэлтгэх хөтөлбөрт өгөх суралцагчдын сэтгэл ханамжийг судлах

Зорилт:

1. Хүний их эмчийн сургалтанд өгөх суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийг судлах
2. Суралцагчдын сэтгэл ханамжид нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох
3. Суралцагчдын сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг судлах

Арга, аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар 2023 оны 6-р сараас 2024 оны 6-р сарын хооронд АШУҮИС-ийн Хүний их эмч мэргэжлээр суралцаж буй нийт 1167 суралцагчдаар үнэлүүлсэн. Судалгаанд хамрагдсан суралцагчдаас хүн амын ерөнхий үзүүлэлтүүд (5 асуулт), ерөнхий сэтгэл ханамж (16 асуулт), нээлттэй хэлбэрийн (2 асуулт) гэсэн нийт 23 асуулт бүхий асуумжийн хуудсаар судалгааг авсан. Судалгаанд хамрагдагчдын сэтгэл ханамжийн түвшинг 5 оноо бүхий Ликертийн хэмжүүрээр үнэлсэн.⁸ (5 – санал бүрэн нийлнэ, 4 – ихэнхдээ санал нийлнэ, 3 – дунд зэрэг нийлнэ, 2 – ихэнхдээ санал нийлэхгүй, 1 – огт санал нийлэхгүй) Судалгааны мэдээллийг IBM SPSS Statistics 26 програмыг ашиглан суралцагчдын үр дүнгийн хувьд холбогдох дескриптив үзүүлэлтүүдийг гаргасан бөгөөд суралцагчдын сэтгэл ханамжийн ялгаатай байдлыг үл хамааралт хоёр түүврийн Т тестээр боловсруулж, (Independent-Sample T Test) 2 ба түүнээс дээш хувьсуурын хоорондын ялгаатай байдлыг ANOVA тестээр боловсруулж, хосолсон Т тест, 16-н чиглэлийн асуумж бүрийн хоорондын хамааралыг корреляци тооцон (Correlation) судалсан, 16 чиглэлийн асуумжийг багцлахдаа (Factor Analysis) хүчин зүйлийн шинжилгээ тооцон үзсэн, багцалсан асуумжийн хооронд хамаарал байгааг нарийвчлан судласан (Simple Linear Regression) ба судалгааны үр дүнгийн хувьд статистик үнэн магадлалыг 95% хувийн ($p < 0.05$) магадлалаар баталгаажуулсан болно.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт 1167 суралцагчдын 20.1% (227) нь эрэгтэй, 79.9% (903) нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийг насны байдлаар нь авч үзвэл дундаж нас нь 22.17 ± 1.5 байлаа. 3-р дамжаанд 33.2% (388), 4-р дамжаанд 21.2% (247), 5-р дамжаанд 29.0% (339), 6-р дамжаанд 16.5% (193) суралцагчид суралцаж байсан.

Нийт суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин - 3.51 ± 0.84 байснаас хамгийн өндөр сэтгэл ханамжийн түвшин нь 4-р дамжааны суралцагчид багш нарын заах арга зүй сайн гэж 3.97 ± 0.67 , хамгийн бага сэтгэл ханамжийн

түвшин нь 3-р дамжааны суралцагчид сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай гэж 2.98 ± 1.01 үнэлсэн байна. Дамжаанаас хамаарах сургалтын үнэлгээний ялгаа (ANOVA) үзүүлэлтийг хүснэгт 1-ээр харуулав.

Дамжаан өндөрсөх тусам сургалтын чанарт тавих шаардлага нэмэгдэж, 6-р дамжааны оюутнуудын сэтгэл ханамж буурч байна. Энэ нь сургалтын нөөц, арга зүйг 6-р дамжаанд тусгайлан сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Хүснэгт 1. Дамжаанаас хамаарах сургалтын үнэлгээний ялгаа (ANOVA)

Үзүүлэлт	Дамжаа	M $\pm$ SD	ANOVA тест р утга
Блок сургалт үр дүнтэй сайн сургалт. (Q1)	3	3.47 $\pm$ 0.86	0.001
	4	3.72 $\pm$ 0.74	
	5	3.55 $\pm$ 0.78	
	6	3.34 $\pm$ 0.79	
Блок сургалтын зохион байгуулалт сайн. (Q2)	3	3.29 $\pm$ 0.89	0.001
	4	3.58 $\pm$ 0.81	
	5	3.40 $\pm$ 0.76	
	6	3.37 $\pm$ 0.81	
Блокуудын хоорондын агуулгын уялдаа холбоо сайн. (Q3)	3	3.60 $\pm$ 0.83	0.014
	4	3.70 $\pm$ 0.77	
	5	3.62 $\pm$ 0.80	
	6	3.45 $\pm$ 0.91	
Лекц, дадлага, семинар, лаборатори, бие даалтын хичээлийн үр өгөөж сайн. (Q4)	3	3.63 $\pm$ 0.76	0.001
	4	3.77 $\pm$ 0.70	
	5	3.52 $\pm$ 0.77	
	6	3.39 $\pm$ 0.82	
Блок дах хичээлүүдийн хоорондын уялдаа, холбоо сайн. (Q5)	3	3.63 $\pm$ 0.78	0.006
	4	3.76 $\pm$ 0.73	
	5	3.68 $\pm$ 0.74	
	6	3.51 $\pm$ 0.82	
Багш нарын заах арга зүй сайн. (Q6)	3	3.80 $\pm$ 0.75	0.014
	4	3.97 $\pm$ 0.67	
	5	3.81 $\pm$ 0.76	
	6	3.77 $\pm$ 0.77	
Хичээлийг явуулж буй арга, хэлбэр тохиромжтой. (Q7)	3	3.62 $\pm$ 0.76	0.001
	4	3.76 $\pm$ 0.70	
	5	3.58 $\pm$ 0.74	
	6	3.46 $\pm$ 0.81	
Миний блок сургалтаар эзэмшиж байгаа мэдлэг, ур чадвар бодитой, шударга үнэлэгддэг. (Q8)	3	3.57 $\pm$ 0.77	0.001
	4	3.74 $\pm$ 0.74	
	5	3.55 $\pm$ 0.77	
	6	3.30 $\pm$ 0.91	
Сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай. (Q11)	3	2.98 $\pm$ 1.01	0.001
	4	3.27 $\pm$ 1.01	
	5	3.22 $\pm$ 0.92	
	6	3.23 $\pm$ 0.92	
Эмнэлзүйн сургалт сайн явагдаж байсан. (Q13)	3	3.70 $\pm$ 0.79	0.001
	4	3.72 $\pm$ 0.86	
	5	3.47 $\pm$ 0.87	
	6	3.16 $\pm$ 0.95	
Сургалтанд би хангалттай сайн оролцож чадсан. (Q16)	3	3.82 $\pm$ 0.74	0.046
	4	3.89 $\pm$ 0.71	
	5	3.78 $\pm$ 0.65	
	6	3.70 $\pm$ 0.81	

Судалгааны асуумжийн найдвартай байдлыг Cronbach's Alpha коэффициентээр үнэлсэн. 16 асуултын дотоод нийцлийн коэффициент $\alpha = 0.927$ байгаа нь маш өндөр найдвартай байдлыг илтгэнэ.⁹ Энэ нь асуумж бүр судалгааны сэдвийг нэгэн чиглэлд бүрэн хамруулж, тогтвортой хэмжилтийг хангаж байгааг харуулж байна. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Асуумжийн найдвартай байдлын шинжилгээ (Cronbach's Alpha)

Үзүүлэлт	Утга
Cronbach's Alpha	0.927
Асуултын тоо (N of Items)	16
Хүчинтэй тохиолдол (Valid Cases)	1167

Корреляцийн матриц нь 16 асуултын хоорондын хамаарлыг Пирсоны корреляцийн коэффициентээр илэрхийлэв. ($**p < 0.01$, $*p < 0.05$.) Хамгийн өндөр корреляци Q1 (Блок сургалт үр дүнтэй сайн) ба Q2 (Блок сургалтын зохион байгуулалт сайн) хооронд ажиглагдсан ($r = 0.647$, $p < 0.01$).

Эдгээр 16 асуумж нь хөтөлбөрт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх зорилго асуумж байгаа тул бид эдгээр асуумжийг багцлахын тулд өөр хооронд нь хамаарал байгаа эсэхийг корреляцийн тооцоолол гаргасан. Бүх асуумж хоорондоо хамааралтай байсан тул цаашид хүчин зүйлсийн шинжилгээ (Factor Analysis) хийв.

Хүчин зүйлийн шинжилгээ хийхэд (Factor Analysis) 16 асуултыг хүчин зүйлийн шинжилгээгээр дараах 2 хүчин зүйлд оновчтой хуваагдлаа:

- 1-р хүчин зүйл: Сургалтын зохион байгуулалт, хичээлийн чанар, агуулга, багшийн арга зүй

- 2-р хүчин зүйл: Сургалтын материаллаг орчин, тоног төхөөрөмж, сурах бичиг, ачаалал

КМО-ийн утга 0.50-аас дээш байвал хангалттай, 0.90-аас дээш нь 'маш сайн' гэж үнэлэгддэг.¹⁰ Энэ судалгаанд 0.950 гэсэн утга гарсан нь өгөгдөл хүчин зүйлийн шинжилгээнд төгс тохирч байгааг харууллаа.¹¹ (Хүснэгт 3.)

Хүснэгт 3. КМО ба Bartlett's Test-ийн үр дүн


Үзүүлэлт	Утга
Kaiser-Meyer-Olkin (КМО)	0.950
Bartlett's Test of Sphericity	$\chi^2 = 9498.102$
Чөлөөний зэрэг (df)	120
Ач холбогдол (p-value)	0.000

Сургалтын чанарын үнэлгээнд сургалтын бүтэц, багшийн арга зүй хамгийн чухал хүчин зүйл болохыг судалгааны үр дүн харуулжээ. Харин материаллаг орчин, ачааллын нөлөө харьцангуй бага байгаа нь эдгээр талбарыг чиглэсэн шинэчлэл хийх шаардлагатайг илтгэнэ. Энэхүү дүгнэлт нь сургалтын бодлого, хөтөлбөрийг шинэчлэхэд чиглэсэн практик арга хэмжээнд үндэслэл болох боломжтой гэж Хүснэгт 4-д харагдаж байна.

Хүснэгт 4. Хүний их эмч бэлтгэх сургалтын чанарын үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлүүд: Хүчин зүйлийн шинжилгээний дүн шинжилгээ

№	Хүчин зүйл	Холбогдох асуултууд
1	Сургалтын зохион байгуулалт, хичээлийн чанар, агуулга, багшийн арга зүй	•Блокуудын уялдаа холбоо сайн •Хичээлүүдийн агуулга сайн •Багшийн арга зүй сайн •Хичээлийн арга, хэлбэр сайн •Блок сургалтын зохион байгуулалт сайн •Блок сургалт үр дүнтэй сайн •Лекц, дадлага, семинар үр өгөөжтэй сайн •Мэдлэг, ур чадварыг бодитой үнэлдэг •Танхимын сургалт сайн
2	Сургалтын материаллаг орчин, тоног төхөөрөмж, сурах бичиг, ачаалал	•Тоног төхөөрөмж, багаж сайн •Өрөө тасалгаа, анги танхим сайн •Сургалтын ном, сурах бичиг, материал хангалттай •Хичээлийн хуваарь зохицуулалт сайн •Сургалтын ачаалал тохиромжтой •Эмнэлзүйн сургалт сайн явагдсан •Оюутны оролцоо сайн

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнгээс харахад нийт 16 асуултын дотоод бүтэц хоёр хүчин зүйлд нэгтгэгдэх нь оновчтой болохыг Scree plot болон eigenvalue > 1 шалгуур харуулсан. Нийт вариацийн 55.83%-ийг эдгээр хоёр хүчин зүйл хамтдаа тайлбарласан нь шинжилгээний өгөгдөл дунд зэргийн тайлбарлах чадвартай байгааг илтгэж байгааг Зураг 1-т харуулав.



Зураг 1. Хүчин зүйлийн шинжилгээгээр үр дүнг тайлбарлах хэмжээ /Суралцагчдын сургалтын үнэлгээний хоёр хүчин зүйлийн загвар/

Судалгааны үр дүн нь сургалтын үнэлгээний суурь бүтэц хоёр томоохон хүчин зүйлд хуваагдаж байгааг нотолж байна. Үүний үр дүнд сургалтын чанарыг 1. сургалтын агуулга ба арга зүй, 2. орчны болон дэмжих хүчин зүйлс гэсэн хоёр үндсэн чиглэлээр сайжруулах стратеги боловсруулах боломжтойг харуулж байна. Иймд сургалтын үнэлгээний хэрэгслүүдийг цаашид хүчин зүйлийн бүтцэд тулгуурлан хялбаршуулан боловсруулах, баталгаажуулах боломжтой байна. Хүчин зүйлийн шинжилгээний эргүүлсэн матрицын (Rotated Component Matrix) үр дүнгээр хоёр үндсэн хүчин зүйл тодорхойлогдсон. Нэгдүгээр хүчин зүйл нь “Хичээлүүдийн хоорондын уялдаа холбоо сайн”

(0.800) өндөр үзүүлэлт, “Сургалтанд би хангалттай сайн” (0.497) зэрэг үзүүлэлт бага үзүүлэлт нь суралцагчдын сэтгэл ханамжид хүчтэй нөлөөтэй болохыг илтгэж байна.

Хоёрдугаар хүчин зүйл нь “Сургалтын материаллаг орчин, техник хангамж, сурах бичиг, сургалтын ачаалал ба оролцоо” гэсэн ангилалд хамаарах үзүүлэлтүүдийг нэгтгэсэн бөгөөд сургалтын тоног төхөөрөмж (0.777), анги танхимын нөхцөл (0.747), сурах бичгийн хүртээмж (0.675), оюутны оролцоо (0.497) зэрэг нь сургалтын сэтгэл ханамжийн өөр нэг томоохон хэмжүүр болдог болохыг харуулж байна. (Хүснэгт 5.)

Хүснэгт 5. Суралцагчдын сургалтын үнэлгээнд үндэслэн тодорхойлсон сургалтын чанарын хоёр хүчин зүйлийн бүтэц

Хувьсуурууд	Хүчин зүйл	
	1	2
Блок дах хичээлүүдийн хоорондын уялдаа, холбоо сайн. (Q5)	0.800	
Блокуудын хоорондын агуулгын уялдаа холбоо сайн. (Q3)	0.767	
Блок сургалт нь үр дүнтэй сайн. (Q1)	0.697	
Багш нарын заах арга зүй сайн. (Q6)	0.666	
Хичээлийг явуулж буй арга, хэлбэр тохиромжтой. (Q7)	0.657	0.434
Блок сургалт нь үр дүнтэй сайн. (Q1)	0.654	
Лекц, дадлага, семинар, лаборатори, бие даалтын хичээлийн үр өгөөж сайн. (Q4)	0.652	
Миний блок сургалтаар эзэмшиж байгаа мэдлэг, ур чадвар бодитой, шударга үнэлэгддэг. (Q8)	0.628	
Танхимын сургалт тохиромжтой сайн байсан. (лекц, дадлага, семинар). (Q12)	0.604	0.460
Эмнэлзүйн сургалт сайн явагдаж байсан. (Q13)	0.526	0.477
Сургалтанд би хангалттай сайн оролцож чадсан. (Q16)	0.497	
Сургалтанд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл сайн. (Q10)		0.777
Өрөө тасалгаа, анги танхим хангалттай сайн. (Q9)		0.747
Сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай. (Q11)		0.675
Сургалтанд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага, ашиглах материал хангалттай. (Q15)		0.674
Оюутны сургалтын ачаалал тохиромжтой. (Q14)		0.574

Суралцагчдын сургалтын зохион байгуулалт, агуулга, багшийн арга зүйд өгсөн үнэлгээ нь дамжаанаас хамаарч өөр өөр байна. Ялангуяа 4-р дамжааны оюутнууд илүү өндөр, 6-р дамжааны оюутнууд илүү бага үнэлгээ өгсөн байна. Сургалтын орчин, тоног төхөөрөмж, ачаалалд өгсөн үнэлгээ нь дамжаануудын хооронд ялгаа байхгүй бөгөөд бүх дамжааныхан бараг ижил үнэлэв. (Хүснэгт 6.)

Үүнээс үндэслэн хамгийн өндөр хариулсан Блок дах хичээлүүдийн хоорондын уялдаа, холбоо сайн (Q5) гэсэн асуумжийг 4-р дамжааны суралцагчдад сэтгэл ханамж эергээр нөлөөлөлөх ямар хүчин зүйлс нөлөөлснийг ANOVA-гаар нарийвсан судлав. (Хүснэгт 7.)

Хүснэгт 6. Багцалсан хүчин зүйлүүдийн үнэлгээ ба дамжааны хамаарал - ANOVA

Дамжааны харьцуулалт	Ялгааны утга	P утга
4-р vs 3-р дамжаа	0.286	0.003
4-р vs 5-р дамжаа	0.287	0.006
4-р vs 6-р дамжаа	0.589	<0.001
6-р vs 3-р дамжаа	-0.303	0.002
6-р vs 5-р дамжаа	-0.302	0.002
3-р vs 5-р дамжаа	0.001	1.000

Корреляцийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд, “Блокуудын хоорондын агуулгын уялдаа холбоо сайн” гэсэн үнэлгээнд координатор багш болон хичээл заадаг багш гэсэн хоёр хувьсагчтай статистикийн хувьд эерэг хамааралтай ($p < 0.05$) байлаа.

Хүснэгт 8-д үзүүлснээр блокийн хичээлүүдийн уялдаа холбоог сайн хангасан гэж үнэлсэн тохиолдолд эдгээр хоёр хүчин зүйлийн үнэлгээ өндөр байх хандлагатай байна. Харин хөтөлбөрийн төлөвлөлт, зохион байгуулалт, сургалтын орчин зэрэг бусад хувьсагчдын хувьд хамаарал статистикийн хувьд ач холбогдолгүй ($p > 0.05$) байсан.

Хүснэгт 7. “Блокуудын хоорондын агуулгын уялдаа холбоо сайн” үнэлгээ ба нөлөөлөх хүчин зүйлсийн хоорондын корреляцийн үр дүн

Хувьсагч	Pearson r	p-утга
Координатор багш	0.30	0.003
Багш	0.28	0.004
Хөтөлбөрийн төлөвлөлт	0.14	0.08
Зохион байгуулалт	0.02	0.80
Сургалтын орчин	0.05	0.60

Мөн хамгийн бага хариулсан сургалтанд би хангалттай сайн оролцож чадсан (Q16) гэсэн асуумжийг 6-р дамжааны суралцагчдад сэтгэл ханамжинд сөргөөр нөлөөлөлөх ямар хүчин зүйлс нөлөөлснийг ANOVA-гаар нарийвсан судлав. (Хүснэгт 8.)

Хүснэгт 8. “Сургалтанд хангалттай сайн оролцсон” үнэлгээнд нөлөөлж буй хувьсагчдын регрессийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	B	β	t	p-утга
Идэвхи, оролцоо	0.210	0.109	1.411	0.160
Суурь мэдлэг	-0.061	-0.034	-0.413	0.680
Гадаад хэлний мэдлэг	0.152	0.092	1.160	0.247
Бие даан суралцах чадвар	0.289	0.148	1.934	0.055
IT, технологи ашиглах чадвар	0.178	0.110	1.400	0.163

Судалгааны үр дүнд “сургалтанд хангалттай сайн оролцсон” үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс дундаас бие даан суралцах чадвар ($p = 0.055$) нь харьцангуй чухал хамааралтай хувьсагч байна. Гэхдээ энэ хамаарал нь borderline буюу хязгаарын утгатай бөгөөд бусад хувьсагчид (идэвхи оролцоо, суурь мэдлэг, хэлний мэдлэг, технологийн чадвар) статистикийн ач холбогдолгүй байв. Үүний улмаас сургалтанд идэвхтэй оролцох байдалд нөлөөлж болох өөр хүчин зүйлс (сэтгэл зүйн хүчин зүйлс, багшийн урамшуулал, сургалтын орчны дэмжлэг гэх мэт)-ийг цаашид нэмж судлах шаардлагатай байна.

Хэлцэмж: Сургалтын чанар, хөтөлбөрийн агуулга нь суралцагчдын сэтгэл ханамжид шууд нөлөөлдөг болохыг олон улсын судалгаанууд харуулж байна. Жишээлбэл, Этиопийн анагаахын сургуулийн судалгаагаар сургалтын хөтөлбөрөө эерэгээр үнэлсэн оюутнууд сургалтын орчиндоо илүү сэтгэл ханамжтай байгааг тогтоосон бөгөөд сургалтын хөтөлбөрийн талаарх эерэг хандлага нь сэтгэл ханамж өндөр байхтай хүчтэй холбоотой ($AOR=2.70$) байв.¹² Түүнчлэн Ази тивийн анагаахын сургуулиудад оюутны сэтгэл ханамжийн түвшин харьцангуй өндөр (50–85% хүртэл) байдаг нь сургалтын агуулга, чанарыг олон улсын түвшинд хүргэхийн ач холбогдлыг харуулдаг.¹³ Энэ нь бидний Сургалтын хөтөлбөрийн чанар, агуулгын үнэлгээ дунджаас дээш түвшинд (сэтгэл ханамжийн дундаж $\sim 3.51 \pm 0.84$) байсан ч энэ үнэлгээ дамжааны түвшнээс хамааран ялгаатай байгаа судалгааны үр дүнтэй ойролцоо байна.¹⁴

Гэвч зарим бүс нутагт сургалтын чанар, хөтөлбөрийн стандартад суралцагчид хангалтгүй гэж үзэх хандлага бий. Пакистанд хийсэн нэг судалгаагаар суралцагчдын дийлэнх нь (57%) сургалтын чанарт сэтгэл дундуур байсан төдийгүй өөрсдийн сургууль дахь сургалтын стандарт олон улсын анагаахын их сургуулиудын хэмжээнд хүрэхгүй байна гэж үзэж байжээ.¹⁵

Иймээс сургалтын хөтөлбөрийн агуулгыг тогтмол шинэчилж, дэлхийн жишигт нийцүүлэх, мөн суралцагчдын санал, хэрэгцээг тусгах нь сэтгэл ханамжийг дээшлүүлэх үндсэн хүчин зүйл болохыг эдгээр үр дүн тусган харуулж байна.¹⁶

Сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах, суралцагчдын оролцоотой хөтөлбөрийн үнэлгээ хийх нь цаашид сургалтын үйл явцыг төгөлдөржүүлж, суралцагчийн суралцах идэвхийг нэмэгдүүлэх чухал арга зам юм.

Багшийн хэрэглэж буй заах арга зүй, үнэлгээний систем нь суралцагчдын сэтгэл ханамжид чухал нөлөө үзүүлдэг. Орчин үеийн идэвхтэй сургалтын аргууд (жишээлбэл, асуудалд суурилсан сургалт) нь уламжлалт лекцийн аргуудаас илүү үр дүнтэй бөгөөд суралцагчдын сэтгэл ханамжийг мэдэгдэхүйц дээшлүүлдэг нь судалгаагаар батлагджээ. Хирургийн сургалтад хийсэн мета-шинжилгээнд PBL (асуудалд суурилсан сургалт) арга нь лекцэд суурилсан аргаас суралцагчдын сэтгэл ханамжийн үзүүлэлтээр илт давуу болох нь тогтоогдсон (сэтгэл ханамжийн үнэлгээний зөрүү $SMD = 2.13$, $p < 0.0001$).¹⁷ Энэ нь сургалтын арга барил суралцагчдын сурах хүсэл сонирхол, үр дүнд хэрхэн нөлөөлдгийг харуулж байна. Суралцагчид ихэвчлэн онолын мэдлэгээс гадна эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэх, бодит тохиолдол дээр тулгуурласан сургалтыг илүүд үздэг бөгөөд ийм оролцоотой аргууд нь тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.

Мөн багшийн үнэлгээ, санал хүсэлт өгөх арга нь суралцагчийн сэтгэл ханамжид нөлөөлөх гол хүчин

зүйлсийн нэг юм. Иранд явуулсан судалгаагаар сургалтын чанарын дэд үзүүлэлтүүдээс “суралцагчдыг үнэлэх ба тогтмол санал хүсэлт өгөх” хүчин зүйл нь суралцагчдын эмнэлзүйн сургалтад сэтгэл ханамжтай байх төлвийг хамгийн сайн таамаглаж байсан бөгөөд эдгээр нь сэтгэл ханамжийн өөрчлөлтийн $\sim 31\%$ -ийг тайлбарлаж байв.¹⁸ Тус судалгааны дүгнэлтээр эмнэлзүйн багш нар суралцагчдад тогтмол, бүтээлч санал хүсэлт өгч, үнэлгээг сайжруулах нь суралцагчдын хөгжлийг дэмжих чухал арга гэж зөвлөсөн байдаг.¹⁹ Үнэлгээний шударга, ил тод байдал, багш нарын мэргэжлийн хандлага нь суралцагчдын итгэлцлийг нэмэгдүүлж, цаашлаад суралцах орчныг эерэг болгодог тул заах арга зүй, үнэлгээний тогтолцоог байнга шинэчлэх шаардлагатай юм.

Суралцагчдын сэтгэл ханамжийн үзүүлэлтийг олон улсын ижил төрлийн судалгаануудтай харьцуулахад дунджаас доогуур/дундаж түвшинд байгааг анзаарах боломжтой байдаг. Олон улсад анагаахын суралцагчдын сэтгэл ханамжийн хувь харилцан адилгүй байдаг ч нийтлэгдээ 50-60%-ийн сэтгэл ханамжтай гэж мэдээлэгдэх нь элбэг бөгөөд зарим оронд энэ үзүүлэлт 80%-д хүрдэг.¹⁹

Тухайлбал, Ази тивд 50–84%-ийн хүрээнд, Европт 42–89%, Африкт 41–65%-ийн хооронд хэлбэлздэг гэж өмнөх судалгаанд мэдээлсэн байна.²⁰

Бидний судалгааны хувь хэмжээ эдгээрийн хаана байрлаж буйг авч үзвэл, сургалтын чанар, орчин нөхцөл зэрэгт илэрсэн давуу болон сул талууд нь бусад улсын адил асуудлууд байгааг харуулж байна. Жишээ нь, бидний судалгааны үр дүнг гарсан (сургалтын орчны сул тал, багшийн арга барил гэх мэт) нь бусад хөгжиж буй орны анагаахын сургуулиудад ажиглагддаг нийтлэг сорилт бөгөөд бидний үр дүн эдгээртэй нийцэж байна. Ийм харьцуулалт нь манай сургуулийн сургалтын хөтөлбөр, орчны давуу сул талыг олон улсын жишигтэй харьцуулан үнэлэх боломжийг олгож, цаашдын сайжруулалтын чиглэлээ тодорхойлох үндэс болно. Эцэст нь, суралцагчдын сэтгэл ханамж өндөр байх нь зөвхөн сургуулийн нэр хүндийн асуудал биш, сургалтын үр дүн, төгсөгчдийн чадварт эерэгээр нөлөөлөх стратегийн ач холбогдолтой. Судалгаануудын үр дүнгээс үзэхэд суралцагчдын суралцах орчиндоо сэтгэл ханамжтай байх нь тэдний сурлагын амжилт, ялангуяа эмнэлзүйн дадал чадвар дээшлэхэд эерэг нөлөө үзүүлдэг байна. Этиопийн судалгаанд хүртэл эмнэлзүйн сургалтад суралцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлснээр тэдний бодит ур чадвар, мэргэшлийн түвшин сайжирч болохыг санал болгосон байдаг. Манай судалгааны дүн ч энэ чиг хандлагыг бататгаж, сэтгэл ханамжийн үзүүлэлт сайжирснаар суралцагчдын өөртөө итгэх итгэл, сурлагын үр дүн дээшлэх төдийгүй, цаашид эмч болох мэргэжлийн замналдаа бэлтгэгдэх чанар нь нэмэгдэх боломжтойг харуулж

байна. Иймд энэхүү судалгааны үр дүнд үндэслэн бид сургалтын чанар, орчин, арга зүй зэрэгт шаардлагатай өөрчлөлт шинэчлэлтийг хийснээр суралцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлж, улмаар сургалтын хөтөлбөрийн үр нөлөөг сайжруулах бүрэн боломжтой гэж дүгнэж байна. Энэ нь эцсийн дүндээ төгсөгчдийн мэдлэг, ур чадвар дээшилж, эрүүл мэндийн үйлчилгээний чанарт хүртэл эергээр нөлөөлөх стратегийн зорилго юм.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан суралцагчдын ерөнхий сэтгэл ханамжийн түвшин дундаас дээгүүр түвшинд байна (дунджаар 3.51 ± 0.84). Сэтгэл ханамжийн хамгийн өндөр үнэлгээ 4-р дамжааны суралцагчид багшийн заах арга зүйд ($M=3.97 \pm 0.67$), хамгийн бага үнэлгээ 3-р дамжааны суралцагчид сургалтын ном, гарын авлага хангалтгүй ($M=2.98 \pm 1.01$) гэсэн үнэлгээнд өгөгдсөн байна. Энэ нь дамжааны түвшин ахих тусам сургалтын чанарт тавигдах хүлээлт нэмэгдэж, сэтгэл ханамж буурч

болохыг харуулж байна.

2. Суралцагчдын сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлсийг 16 асуумжаар тодруулсан ба хүчин зүйлсийн шинжилгээгээр (factory analysis) статистик ач холбогдол бүхий 2 хүчин зүйлд оновчтой хуваагдсан ба нийт үр дүнгийн 55.83%-ийг тайлбарлаж байв. (КМО - 0.950; $p < 0.05$)

3. Корреляцийн болон регрессийн шинжилгээний үр дүнд сургалтын уялдаа холбооны үнэлгээ (Q3) нь координатор багш ($r = 0.30$, $p = 0.003$) болон хичээл заадаг багш ($r = 0.28$, $p = 0.004$) гэсэн хувьсагчидтай статистикийн ач холбогдол бүхий эерэг хамааралтай байв. Харин “Сургалтанд хангалттай сайн оролцсон” (Q16) үнэлгээнд бие даан суралцах чадвар ($p = 0.055$) хязгаарлагдмал ач холбогдолтой гарч, бусад хувьсагчид ач холбогдолгүй байв ($p > 0.05$). Энэ нь сургалтын чанарт нөлөөлөх илүү гүнзгий хүчин зүйлсийг цаашид судлах шаардлагатайг харуулж байна.

Ном зүй:

1. International Innovation Platform (IIP). *Reimagining Outcome-Based Education: A Global Perspective. Continuous Improvement and Quality Assurance in OBE Systems. International Innovation Platform*; 2024. Accessed April 13, 2025. <https://iipseries.org/assets/docupload/rsi2024C4E923F870BAE05.pdf>
2. Albanese MA, Mitchell S. Problem-based learning: a review of literature on its outcomes and implementation issues. *Acad Med*. 1993;68(1):52-81.
3. Prideaux D. Curriculum development in medical education: from acronyms to dynamism. *Teach Teach Educ*. 2007;23(3):294-302. doi:10.1016/j.tate.2006.12.016
4. Biggs J, Tang C. *Teaching for Quality Learning at University*. 4th ed. McGraw-Hill Education; 2011
5. Badamdorj O, Erkhembayar R, Gombo B, et al. Medical education in Mongolia: challenges and opportunities. *Med Teach*. Published online April 8, 2024. doi:10.1080/0142159X.2024.2336077
6. Meyboom-de Jong B, van Weert HC. Veranderingen in de medische opleiding in Mongolië [Changes in the medical curriculum in Mongolia]. *Ned Tijdschr Geneesk*. 2005;149(29):1641-1645.
7. Alshammari F, Alshammari M, Alshammari T, et al. Predictors of nursing student satisfaction as a key quality indicator of nursing education: a cross-sectional study. *Nurse Educ Today*. 2023;126:105846. doi:10.1016/j.nedt.2023.105846
8. Likert R. A technique for the measurement of attitudes. *Arch Psychol*. 1932;140:1-55.
9. Cronbach LJ. Coefficient alpha and the internal structure of tests. *Psychometrika*. 1951;16(3):297-334. doi:10.1007/BF02310555
10. Kaiser HF. An index of factorial simplicity. *Psychometrika*. 1974;39(1):31-36. doi:10.1007/BF02291575
11. Tabachnick BG, Fidell LS. *Using Multivariate Statistics*. 7th ed. Pearson; 2018.
12. Ayenew T, Tadesse AF, Fikru T, et al. Satisfaction of medical and health science students with their clinical learning environment and its determinant factors at Debre Markos University, northwest Ethiopia. *BMC Med Educ*. 2024;24:1113. doi:10.1186/s12909-024-06114-6
13. Manzar B, Manzar N. To determine the level of satisfaction among medical students of a public sector medical university regarding their academic activities. *BMC Res Notes*. 2011;4:380. doi:10.1186/1756-0500-4-380
14. Zheng QM, Li YY, Yin Q, et al. The effectiveness of problem-based learning compared with lecture-based learning in surgical education: a systematic review and meta-analysis. *BMC Med Educ*. 2023;23(1):546. doi:10.1186/s12909-023-04531-7
15. Amini K, Salehzadeh M, Noktehsanj R. Assessing the relationship between teaching quality and satisfaction with clinical teachers among medical students: a correlational cross-sectional study. *BMJ Open*. 2024;14(12):e088351. doi:10.1136/bmjopen-2024-088351
16. Pai PG, Menezes V, Srikanth, Subramanian AM, Shenoy JP. Medical students' perception of their educational environment. *J Clin Diagn Res*. 2014;8(1):103-107. doi:10.7860/JCDR/2014/5559.3944
17. Roff S, McAleer S, Harden RM, et al. Development and validation of the Dundee Ready Education Environment Measure (DREEM). *Med Teach*. 1997;19(4):295-299. doi:10.3109/01421599709034208
18. Karle H. Global standards and accreditation in medical education: a view from the WFME. *Acad Med*. 2006;81(12 Suppl):S43-S48. doi:10.1097/01.ACM.0000243383.71030.ec
19. Doman T, Scherpbier A, Boshuizen H. Supporting medical students' workplace learning: experience-based learning (ExBL). *Med Educ*. 2009;43(1):73-80. doi:10.1111/j.1365-2923.2008.03245.x
20. Maher BM, Hynes H, Sweeney C, Khashan AS, O'Rourke M, Doran G. Medical school attrition—beyond the statistics: a ten year retrospective study. *BMC Med Educ*. 2013;13:13. doi:10.1186/1472-6920-13-13
21. Muldoon OT, Downes C, Kavanagh L, et al. Student experiences and perceptions of learning in medical education: A systematic review. *Med Educ*. 2020;54(12):1111-1122. doi:10.1111/medu.14270
22. Salam A, Yusoff MSB, Yasin MA, Ibrahim MI. Validity and reliability of the DREEM in a Malaysian medical school. *Med Educ Online*. 2015;20:29530. doi:10.3402/meo.v20.29530
23. Sayedalam Z, Halabi OA, Lomis KD, et al. The impact of medical education reform on students' perceptions of learning environments: a cross-sectional study. *BMC Med Educ*. 2021;21(1):453. doi:10.1186/s12909-021-02949-w
24. Nair BR, Coughlan JL, Hensley MJ. Student and patient perspectives on bedside teaching. *Med Educ*. 1998;32(2):168-172. doi:10.1046/j.1365-2923.1998.00196.x

Medical Students' Evaluation of the Outcomes of the Undergraduate Medical Education Program

Usukhbayar M¹, Erdenekhuu N², Enkhtur Ya³, Oyungoo B⁴

¹ Department of family medicine, School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

² National cancer center of mongolia

³ School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

⁴ School of Nursing, Mongolian National University of Medical Sciences

Email: usukhbayar@mnums.edu.mn, Phone number: 99080154

Keywords:

Outcome-Based Education (OBE), Learning Evaluation, Student Satisfaction, Factor Analysis

Background: Modern medical education increasingly integrates Outcome-Based Education (OBE) and Problem-Based Learning (PBL) approaches to improve training quality. The Mongolian National University of Medical Sciences (MNUMS) implemented an OBE curriculum in 2013, creating a need to examine student satisfaction as a measure of program effectiveness. Student satisfaction is recognized as a key indicator of educational quality and is linked to outcomes such as graduate retention and institutional reputation.

Aim: To assess the level of student satisfaction in the medical doctor (MD) training program and identify factors influencing it, in order to provide a basis for improving training quality.

Materials and Methods: A cross-sectional survey was conducted in 2023–2024 among 1167 students (third- to sixth-year MD students) at MNUMS. Participants had a mean age of 22.2 ± 1.5 years, and 79.9% were female. A questionnaire with 23 questions (including 16 Likert-scale items on satisfaction) was administered; responses were given on a 5-point Likert scale. Data were analyzed using SPSS version 26. Descriptive statistics, independent t-tests, one-way ANOVA, Pearson correlation analysis, exploratory factor analysis, and multiple linear regression were performed. All statistical tests were two-tailed, and significance was set at $p < 0.05$.

Results: The satisfaction survey demonstrated high internal consistency (Cronbach's $\alpha = 0.927$). Overall satisfaction with the training program was moderately high, with a mean score of 3.51 ± 0.84 out of 5. Fourth-year students reported the highest satisfaction with teaching methods (mean 3.97 ± 0.67), whereas third-year students gave the lowest rating for the sufficiency of learning materials (mean 2.98 ± 1.01); these differences were statistically significant ($p < 0.001$). Additionally, satisfaction with clinical training declined by the final year of study, with a mean rating of 3.16 in the sixth year compared to 3.70 in the third year ($p < 0.001$). No significant difference in overall satisfaction was observed between male and female students ($p > 0.05$). Exploratory factor analysis (KMO = 0.950; Bartlett's test $p < 0.001$) identified two key underlying factors influencing perceived training quality, which together explained 55.83% of the total variance: (1) "Curriculum organization and teaching methodology," and (2) "Material resources and learning environment." Correlation and regression analyses further indicated that better course organization and active teacher engagement were associated with higher student satisfaction ($p < 0.01$).

Conclusion: The study shows that enhancing teaching methods and improving curriculum coherence are needed to further improve the quality of the MD training program. Additionally, strengthening educational resources and updating instructional approaches are crucial for raising satisfaction levels, particularly for senior (sixth-year) students. These findings provide an evidence-based foundation for curriculum and policy improvements to boost student satisfaction and overall educational outcomes.